



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: - Төрийн нарийн бичгийн дарга,
Гишүүд: -Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга,
- Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга,
- Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,
- Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга,
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга: - Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 1 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЦОГОО



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх
салбар зөвлөлийн даргыг томилох тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, 4.3.4, "Ажилд томилох тухай" Засгийн газрын 2016 оны 18 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоол, "Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" мөн Зөвлөлийн 2016 оны 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цэгмидийн Цэнгэлийг 2016 оны 11 дүгээр сарын 28 -ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар томилсугай.

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Ц.Цэнгэлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦОГОО